



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС
ЗӨВЛӨМЖ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 05

Номгон

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг (Цаашид “журам” гэж хэрэглэх) удирдлага болгон аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 162 арга хэмжээний 14 хувь нь үр дүн гарч эхэлсэн; 20 хувь нь тавьсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа; 24 хувь нь тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын ажил бүрэн хийгдсэн, ажил тодорхой хэмжээнд эхэлж байгаа; 32 хувь нь тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатандаа; 10 хувь нь тодорхой үр дүнгүй байна. хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

1.Бодлогын хэлтсүүд тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ бүрийг төгөлдөржүүлэн, бүрэн үр дүнд хүргэх, үр дүнгүй 16 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 51 арга хэмжээг онцгойлон анхаарч, эрчимжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж, сум, агентлагийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах

2.Арга хэмжээ нэг бүрийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг анхаарч, ерөнхий биш тодорхой, тоон ба чанарын үзүүлэлтийг суурь түвшинтэй

642022010

харьцуулсан байдлаар тайлагнах, зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийг дурдан, үр дүнг илэрхийлэн тайлагнах, нотлох баримтыг хавсаргах

3. Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан журмыг баримтлан бодитой үнэлж, цаг хугацаанд нь тайлагнах;

4. Салбар хоорондын уялдааг хангаж, хамтарч ажиллах;

5. Сумдын төрийн албан хаагчдыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах, арга хэмжээнүүдийн гүйцэтгэлийг чанаржуулах;


6. Төсөв байхгүйн улмаас хэрэгжээгүй 2.3.14; 3.2.7; 5.1.11; 5.1.27; 7.1.17 арга хэмжээнүүдийн төсвийн асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх;

7. Цаашид төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүжилт болон бусад нөөцийг судалсны үндсэн дээр батлуулах;

8. Зөвлөмжийн хэрэгжилтийг 2022 оны 10 дугаар сарын 01-ний дотор ирүүлэхийг зөвлөж байна.

Зөвлөмжид Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөнд хийсэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг хавсаргав.

Хавсралт 10 хуудастай.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА  Л.МАНДАЛ

**БАЯНХОНГОР АЙМГИЙН 2022 ОНЫ ХӨГЖЛИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТАЙЛАН**

2022 оны 06 дугаар сарын 30

Номгон

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй:

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, үр дүнг 2022 оны эхний хагас жилийн байдлаар үнэлэн удирдлагуудыг мэдээллээр хангах, гүйцэтгэгч байгууллага, албан хаагчдад зөвлөмж, чиглэл өгөхөд оршино.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагад хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, нутгийн захиргааны болон орон нутгийн өмчит байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг (Цаашид “журам” гэж хэрэглэх) удирдлага болгон аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Үнэлгээг аймгийн Засаг даргын А/286 дугаар захирамжаар батлагдсан журмын нэгдүгээр хавсралтаар батлагдсан цаглавраар 2022 оны 05 дугаар сарын 15-наас өмнөх байдлаар гарсан тайланд хийсэн болно.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн:

Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөг Монгол Улсын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.6-д (энэхүү заалт 2021 оны 12 сарын 16-ны хуулиар өөрчлөгдсөн) заасны дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/23 дугаар тогтоолоор “Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай шийдвэрээр 7 бүлэг, 162 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна.


Хэрэгжилтийн тайланг Баянхонгор аймгийн Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангаар хүлээн авсан ба аймгийн Засаг даргын Тамгын газрын 7 хэлтэс, 19 сум, 20 агентлаг тайлагнасан байна. Аймгийн нэгдсэн тайланг журмын 4.4 дэх заалтын дагуу Захиргаа, хүний нөөц, дотоод ажил хариуцсан нэгж нэгтгэн ирүүлсэн тайланд үнэлгээ хийлээ.

Тайланг Боловсрол, шинжлэх ухааны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, Биеийн тамир, спортын газар; Газрын харилцаа, барилга хот

байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, Санхүүгийн хяналт, аудитын алба, Татварын хэлтэс, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Цагдаагийн газар, Мал эмнэлгийн газар зэрэг агентлагууд, Баацагаан, Баянбулаг, Баянговь, Бууцагаан, Галуут, Жаргалант, Өлзийт, Хүрээмарал, Шинэжинст, Баянхонгор зэрэг сумд, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс, Санхүү, төрийн сангийн хэлтсүүд хугацаандаа тайлагнасан байна. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Ус, цаг уур, орчны шинжилгээний газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Эрүүл мэндийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Соёл, урлагийн газар зэрэг агентлагууд, Баянлиг, Баян-Овоо, Баян-Өндөр, Баянцагаан, Богд, Гурванбулаг, Жинст, Заг, Эрдэнэцогт сумд хугацаа хоцроож тайлагнасан. Бөмбөгөр сум огт тайлагнаагүй. Тайлагнасан нийт байгууллагын 51,2 хувь нь хугацаандаа тайлагнасан, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсүүдийн 37,5 хувь нь хугацаандаа тайлагнасан байна.

Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөө эхний хагас жилийн байдлаар 48.8 хувийн хэрэгжилттэй байгааг дараах зурагт үзүүлээ.

Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөний үнэлгээ
(2022 оны эхний хагас жил)



Аймгийн жилийн хөгжлийн төлөвлөгөөний Хүний хөгжлийн бодлого зорилтын 1 арга хэмжээ, Амар тайван, аюулгүй нийгэм зорилтын 2 арга хэмжээ, Засаглалын бодлого зорилтын 2, нийт 5 арга хэмжээ бүрэн хэрэгжсэн байна. Үүнд:

➤ Төлөвлөгөөний 1.5.5.Хүнсний эрхийн бичигт хамрагдсан иргэдэд хяналт мониторинг хийж хөдөлмөрт бэлтгэх;

➤ Төлөвлөгөөний 6.1.4.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогч нарын ар гэрийнхэнтэйгээ уулзах өрөөг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулж, орчин нөхцөлийг сайжруулах;

➤ Төлөвлөгөөний 6.2.2.Аймгийн Засаг даргын нэрэмжит Батлан хамгаалах болон хууль сахиулах байгууллагуудын дунд зохион байгуулагдах спортын болон марш тактик тусгай бэлтгэлийн аварга тасаг шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах;

➤ Төлөвлөгөөний 7.1.10.Төрийн цахим шилжилтийн үр дүнг таниулах, тоон бичиг үсгийн чадварыг дээшлүүлэх "Inspire 2022 цахим шилжилтийг хүн бүрт" төслийг хэрэгжүүлэх;

➤ Төлөвлөгөөний 7.1.12. Сумдын газрын даамлуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх;

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд нийт арга хэмжээний 34,5 хувь нь тодорхой үр дүнд байгаа хэдий ч зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай 91 арга хэмжээ байна. Гэрээ боловсруулах, байгуулах, төсөл боловсруулах, судалгаа хийх шатанд байгаа, гэрээ дөнгөж байгуулагдаад ажил эхлээгүй байгаа дараах 51 арга хэмжээ байна.

Д/д	Зорилт	Арга хэмжээ
1	2	3
1.	2.1. Эрүүл иргэн-Ирээдүйн үнэт зүйл	2.1.1. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээг хэрэгжүүлэх
2.		2.1.5. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангаж, нэн шаардлагатай эмч мэргэжилтнийг бэлтгэх
3.		2.1.7. "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат зорилтот үйл ажиллагаа хэрэгжүүлэх
4.		2.1.9. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн барилгын явцыг 80 хувьд хүргэх.
5.		2.1.10. Заг, Галуут сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын тасгийн эмнэлгийн барилгыг засварлах
6.		2.1.11. Баянхонгор сумын Оточ номгон өрхийн эмнэлэг барих
7.	2.2. Идэвхитэй амьдрал – Чийрэг иргэн	2.2.5. Ламын гэгээний их тойром шагайн харваа зохион байгуулах
9.		2.3.2. Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн барилгад их засвар хийх
10.		2.3.6. Жаргалант сумын сургуулийн их засвар
11.		2.3.7. Баян-Овоо сумын сургуулийн дотуур байрны барилгад их засвар хийх
12.		2.3.10. Боловсролын салбарын тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх

1	2	3
13.		2.3.11. Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмж
14.		2.3.13. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх.
15.		2.3.18. Төрийн албан хаагч, иргэдийн үндэсний бичгийн чадварыг сайжруулах, төрийн албыг үндэсний бичгээр эрхлэх бэлтгэлийг хангах
16.	2.5. Халамжаас - Хөдөлмөрт	2.5.2. Ахмад настан, өрх толгойлсон эцэг, эх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих
17.		2.5.6. Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчид, ажил хайж буй залуучуудад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйлчилгээг зохион байгуулах
18.		2.5.8. Коллеж төгсөгчдийг ажлын байраар хангах замаар Бизнес инкубаторын үйлчилгээг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
19.	2.6. Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ	2.6.2. Ч.Лхамсүрэнгийн нэрэмжит "Хүрэн морь" яруу найргийн наадам зохион байгуулах
20.	2.7. Хонгорын иргэн-Хонгорын баялаг	2.7.2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийг чадавхжуулах /оролцоо/
21.		2.7.4. "Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр"-ийн засаглал, хамгааллын зорилтыг хэрэгжүүлэх
22.	3.2. Өрсөлдөх чадвартай брэнд бүтээгдэхүүн	3.2.4. Хөдөө аж ахуйн кластер төслийн газар тариалан, малын тэжээл дэд төслийн ажлыг эхлүүлэх
23.		3.2.5. Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ хөдөө төслийг хэрэгжүүлэх
24.		3.2.6. Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж
25.		3.2.7. Үзэсгэлэн худалдаа гаргах зориулалтын /асар/ талбай байгуулж, Жижиг дунд үйлдвэрлэл, Мал аж ахуй, Газар тариалан эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах сувгийг нээж, орлого нэмэгдүүлэх.
26.	4.1. Эх байгаль-Ногоон	4.1.2. Түйн голын сав дагуу ойн зурвас бий болгож мод үржүүлгийн талбай байгуулах
27.	байгууламж	4.1.9. Аймгийн хэмжээний цөлжиж буй газрын судалгааг хийлгэх
28.		4.1.10. Ус ашиглагч томоохон аж ахуйн нэгжүүдийн ус зарилалтад байнгын хяналт тавих
29.		4.1.13. Бөөнцагаан нууранд шувуу ажиглах байр барих
30.		4.1.16. Аялал жуулчлалын нөөц газар Их Богд хайрханы Цонж өгчмыг тохижуулж, аяллын маршрутыг тогтоох
31.		4.1.17. Аялал жуулчлалын эвент арга хэмжээ, сарлагийн баяр, өвлийн наадам, тэмээний баяр, Ай Ти Эм арга хэмжээнд оролцох
32.	5.1. Ээлтэй төлөвлөлт, эрсдэлгүй амьдрал	5.1.6. Эрдэнэмандал сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах
33.		5.1.7. Аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах
34.		5.1.8. Шаардлагатай сумдын шороон замын зураг төсөв боловсруулах, засвар үйлчилгээ хийх (Баянговь, Баянлиг, Баянцагаан, Баянцагаан, Шинэжинст, Эрдэнэцогт, Баянөндөр)
35.		5.1.9. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг эхлүүлэх
36.		5.1.12. Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сулжээг хийх
37.		5.1.14. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын

1	2	3
		өргөтгөл, шинэчлэлтийг хийх
38.		5.1.15. Шаардлагатай газруудад цахилгаан шугам, дэд станцын өргөтгөл хийх (5.6 км иж бүрэн шугам, 2 дэд станцын өргөтгөл хийх)
39.		5.1.17. Хүрээмарал сумын Сувраа уулын орой дахь Жи-Мобайлын сүлжээг дахин дамжуулах станцын өргөтгөл шинэчлэл хийх
40.		5.1.18. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станцын барилга угсралтын ажлыг эхлүүлэх
41.		5.1.19. Гурван бүсийн цогцолбор цэцэрлэгт хүрээлэнгийн их засварын ажлыг хийх
42.		5.1.21. Баацагаан сумд орон сууцжуулах төслийн дэд бүтцийн ажлыг эхлүүлэх
43.		5.1.25. Аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл
44.		5.1.26. Баянхонгор сумын гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээний ажлыг эхлүүлэх
45.	6.1. Аюулгүй нийгэм, амар тайлан орчин	6.1.3. Жаргалант, Богд сумдын цагдаагийн тасгийг шинэ байртай болох
46.		6.1.6. Хилийн 0203 дугаар салбар (Хатансуудал)-ын цэргийн байранд халаалтын нэгдсэн шугам, хилийн 0112 дугаар салбар /Цагаанбогд/-ын албаны байруудад засвар хийх ажилд дэмжлэг үзүүлэх
47.	7.1. Ухаалаг засаглал	7.1.3. Хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийлгэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах
48.		7.1.4. "Нийгмийн салбарын үйлчилгээний хүртээмж, чанар" судалгаа хийх
49.		7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан программ хангамж хөгжүүлэх
50.		7.1.7. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх
51.		7.1.9. Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск (өөртөө үйлчлэх) машины систем хөгжүүлэн нэвтрүүлж, төрийн байгууллагууд болон нийтийн үйлчилгээний газруудад нэвтрүүлнэ

Аймгийн 2022 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд үр дүнгүй, огт зохион байгуулалтын ажил эхлээгүй дараах 16 арга хэмжээ байна.

Д/д	Зорилт	Арга хэмжээ
1	2	3
1.	2.3.Боловсролын чанар-хөгжлийн тулгуур	2.3.4. Баянхонгор сумын 5-р сургуулийг цэвэр усны шугамд тохижуулах
2.	2.5.Халамжаас - Хөдөлмөрт	2.5.1. Гарааны бизнес эрхлэгч залуучуудын үйл ажиллагааг дэмжих, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх
1.	2.6.Соёлтой иргэн-Нийгмийг түүчээлнэ	2.6.6. Аймгийн Хөгжимт драмын театрт их засвар хийх
2.		2.6.7. Эрдэнэмандал хайрханы бурханы засвар, тохижилтын ажлыг хийх
3.		2.6.8. Бөмбөгөр сумд Гэрэлт хөшөө байгуулах

1	2	3
4.	4.1.Эх байгаль-Ногоон байгууламж	4.1.6. Түйн голын бургасанд хортон шавьжны устгал хийх
5.		4.1.15. Аялал жуулчлалын нөөц газруудын судалгааг эрдэмтдийн багтай хамтран хийх
6.		4.1.18. Аймгийн хуучин хогийн цэгт техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийх
7.		4.1.20. Баянхонгор сумын 9 багт хоёрдогч түүхий эд худалдан авах цэгүүдийг байгуулах
8.	5.1.Ээлтэй төлөвлөлт-Эрсдэлгүй амьдрал	5.1.11. Хот хоорондын ачаа, тээвэр, сум хоорондын тээвэр, нүүрс, түлээ, амьд мал худалдаалах нэгдсэн цэг байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх
9.		5.1.13. Баянхонгор сумын инженерийн шугам сүлжээний тооллогын ажлыг эхлүүлж мэдээллийн санд оруулах
10.		5.1.27. Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын бүс бий болж байгаатай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах
11.		5.1.28. Баянхонгор сумын ундны усны харуул хамгаалалт
12.		5.1.29. Үүрэн холбооны сүлжээ
13.	6.1.Аюулгүй нийгэм-амар тайван орчин	6.1.7. Баянхонгор сумын 2, 3, 7 багийн гудамжны гэрэлтүүлгийг нэмэгдүүлэх
14.	7.1. Ухаалаг засаглал	7.1.17. Хурлын ажлын албаны ажиллах хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашиныг шинэчлэх

Хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан дараах арга хэмжээнүүд төсөв байхгүйн улмаас хэрэгжээгүй байна. Үүнд:

1.Төлөвлөгөөний 2.3.14-д Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэл үйлчилгээнд үе шаттайгаар хамруулах: Шинэжинст, Жаргалант сумын хувьд хараахан шийдээгүй байна.


2. Төлөвлөгөөний 3.2.7-д Үзэсгэлэн худалдаа гаргах зориулалтын /асар/ талбай байгуулж, Жижиг дунд үйлдвэрлэл, Мал аж ахуй, Газар тариалан эрхлэгчдийн бараа бүтээгдэхүүнийг худалдан борлуулах сувгийг нээж, орлого нэмэгдүүлэх: Үзэсгэлэн худалдааг зөвхөн байгуулж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг ая тухтай үйлчилгээ үзүүлэхэд дэмжлэг болгож асар майхан худалдан авахаар үнийн болон аж ахуй нэгжийн судалгааг хийсэн. Худалдан авах хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй.

3.Төлөвлөгөөний 5.1.11-д Хот хоорондын ачаа, тээвэр, сум хоорондын тээвэр, нүүрс, түлээ, амьд мал худалдаалах нэгдсэн цэг байгуулах асуудлыг судалж шийдвэрлүүлэх: Зураг төсөв боловсруулагдаж байгаа 2023 оны төсөвт тусгагдсан.


4.Төлөвлөгөөний 5.1.27-д Баянхонгор аймгийн төвд шинэ суурьшлын бүс бий болж байгаатай холбоотойгоор ус хангамжийн эх үүсвэрт 5 дахь худаг гаргах ажил хийгдээгүй.

5. Төлөвлөгөөний 7.1.17-д Хурлын ажлын албаны ажиллах хэвийн үйл ажиллагааг хангаж, автомашиныг шинэчлэх ажил Хэмнэлтийн хууль хэрэгжсэн, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй нь улмаас автомашин худалдаж аваагүй.

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний хэлтсүүдийн хэрэгжилтийн тайлан 41-78 хувийн гүйцэтгэлтэй байна, дундаж хэрэгжилт 57,3 хувь.




Агентлагуудын тайлан 35-100 хувийн хэрэгжилттэй, дундаж 62,8 хувь.



Сумдын үнэлгээ 25,8-50 хувь байгаа ба дундаж хэрэгжилт 35,5 хувьтай байна.

Сумдын үнэлгээ



Сумдын тайлантай танилцахад:

- 1.Төлөвлөгөөний 2.1.2-д "Аймгийн 18-аас дээш насны иргэдийг урьдчилан сэргийлэх үзлэг, оношлогоонд хамруулах" арга хэмжээ Баянбулаг, Баян-Овоо, Баянцагаан, Богд, Өлзийт, Шинэжинст сумдаас бусад сумдад хэрэгжээгүй.
2. Төлөвлөгөөний 3.1.6-д Сумдын санхүүгийн албаны 20 нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр төсвөөг цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжийг шинэчлэх арга хэмжээний төсөл төхөөрөмж шинэчлэх ажил сумдад хэрэгжээгүй байна.
- 3.Төлөвлөгөөний 3.3.2-д Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлж, уст цэгийн хайгуул хийх ажил Хүнс хөдөө аж ахуйн газарт санал хүргүүлсэн, хэрэгжээгүй.
- 4.Төлөвлөгөөний 3.3.4-д Намгаалагдсан хөрсний тариалалтыг нэмэгдүүлж, нэгдсэн зохион байгуулалттайгоор хүлэмж нийлүүлэх төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх ажил Баянбулаг сум СУХО-аар шийдсэн, Баянлиг, Баян-Овоо, Богд, Бууцагаан, Жаргалант, Жинст, Өлзийт, Баянхонгор сум иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх шатанд байгаа, бусад сумдад хэрэгжээгүй байна.
- 5.Төлөвлөгөөний 7.1.6-д "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хэрэгжүүлэлт хийх. Үүнд:1. Үндсэн сайтын нэмэлт хөгжүүлэлт, 2. Сумдын сайтын нэмэлт хөгжүүлэлт хийгдээгүй.
- 6.Төлөвлөгөөний 7.1.7-д 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний байр, газар, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан програм хангамж хөгжүүлэх ажил хийгдээгүй.

7.Төлөвлөгөөний 7.1.7-д 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, хорооллын мэдээллийг цахимжуулах 360 технологид суурилсан гар утасны АПП (iOS, Android) хөгжүүлэх арга хэмжээнүүд бүх сумдад хэрэгжээгүй байна.

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 48 хэлтэс, агентлаг, сумдын тайлантай танилцахад нэг арга хэмжээний гүйцэтгэлийг оновчтой, товч тодорхой, иж бүрэн, нотлох баримттай тайлагнах чадвар сул байгаагаас тайлангийн үнэлгээ буурч байна. Үнэлгээг бууруулсан арга хэмжээ бүрийн дутагдлыг засах зөвлөмжийг байгууллага, хэлтэс, сумдын цахим тайланд системээр өгсөн болно.

Гурав. Дүгнэлт

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 162 арга хэмжээний 14 хувь нь үр дүн гарч эхэлсэн, 20 хувь нь тавьсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор өөрснөөс хараарах шийдвэрийг гаргасан, санхүүгийн асуудал шийдвэрлэгдсэн гүйцэтгэл нь тодорхой хэмжээгээр гарч эхэлж байгаа, 24 хувь нь тухайн зорилт арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын ажил бүрэн хийгдсэн, эцэст тодорхой хэмжээнд эхэлж байгаа, 32 хувь нь тухайн зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх бэлтгэл болон боловсруулалтын шатандаа, 10 хувь нь тодорхой үр дүндүй байна.

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 162 арга хэмжээний дүн

Эрчимжүүлэх шаардлагатай, 91 арга хэмжээнээс ажил эхлээгүй байгаа 51 арга хэмжээ болон үр дүнгүй байгаа 16 арга хэмжээнд онцгой ач холбогдол өгч, хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

■ 10 хувь

■ 20 хувь

Аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний 2.3.14; 3.2.7; 5.1.11; 5.1.27; 7.1.17 дахь зүйл, арга хэмжээнүүд төсөв, эх үүсвэргүй байдлаас шалтгаалан хэрэгжихгүй болжээ. Төрийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 5.1.6-д заасан нөөц, зардал, хөрөнгийг мөрдөж эхэлсэн байх зарчмыг зөрчсөн байна.

Дөрөв.Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ /зөвлөмж/

- 1.Бодлогын хэлтсүүд тодорхой үр дүнд хүрсэн арга хэмжээ бүрийг төгөлдөржүүлэн, бүрэн үр дүнд хүргэх, үр дүнгүй 16 арга хэмжээ, эрчимжүүлэх шаардлагатай 51 арга хэмжээг онцгойлон анхаарч, эрчимжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж, сум, агентлагийг мэргэжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах;
- 2.Арга хэмжээ нэг бүрийг тайлагнахдаа хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтийг анхаарч, ерөнхий биш тодорхой, тоон ба чанарын үзүүлэлтийг суурь түвшинтэй харьцуулсан байдлаар тайлагнах, зарцуулсан санхүүжилт, эх үүсвэрийг дурдан, үр дүнг илэрхийлэн тайлагнах, нотлох баримтыг хавсаргах;
3. Аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан журмыг баримтлан Бюджетийг үнэмж, цаг хугацаанд нь тайлагнах;
- 4.Салбар хөрөнгийн мөрдөж хангаж, хамтарч ажиллах;
- 5.Сумдын төрийн албан хаагчдыг мэргэжил арга зүй, удирдлагаар хангаж ажиллах, арга хэмжээгүүдийн гүйцэтгэлийг чанаржуулах;
- 6.Төсөв байхгүйн улмаас хэрэгжээгүй 2.3.14; 3.2.7; 5.1.11; 5.1.27; 7.1.17 арга хэмжээнүүдийг нэгжлийн агуулгыг шийдвэрлэж, хэрэгжүүлэх;
- 7.Цаашид төлөвлөгөө, төрөллөлтийн баримт бичиг боловсруулахдаа Хөгжлийн бодлого, төлөвлөгөөний хууль, тогтоомжид нийцүүлэн санхүүжилт болон бусад нөөц зарцуулах шаардлагатай байна.

ХАШИГСАН:


ХАШИГСАН ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХАШИГСАН ДАРГА

ХАШИГСАН БИЧСЭН:

ХАШИГСАН ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ

ХАШИГСАН МЭРГЭЖИЛТЭН



Л.МАНДАЛ

Б.БУЛГАМАА